

## ОХУ-ЫН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ 2003 ОНЫ БАЙДЛААР

*К.Дэмбэрэл\**

Монголын махны үйлдвэрлэл нь манай эдийн засгийн гол салбаруудын нэг. Гадаад валютын нэг эх сурвалж. Энэ салбарын экспорт голлон ОХУ руу чиглэж ирсэн. Монголын малын махаар ажиллах төлөвлөгөөтэй үйлдвэрүүдийг ч Оросууд байгуулж байсан. Гэхдээ манай махны экспорт хил орчмын субъектуудын үйлдвэрээр хязгаарлагдсаар ирлээ. Хил орчмын үйлдвэрүүдийн нийтлэг шинж бол төлбөрийн чадвар сул, менежментийн хувьд хоцрогдсон, технологио төгс шинэчлэж чадаагүй гэх зэргийн сул талууд бий. Манай хоёр улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн энэ жилүүдэд тохиолдож буй хүндрэл махны үйлдвэрлэлийн салбарт мөн л адилаар туссан. Сүүлийн 10 жилд энэ чиглэлээр ажиллаж байгаа хоёр талын аж ахуйн нэгжүүдийн хоорондын маргаантай асуудлууд засгийн газар хоорондын комиссын хуралдаанаар хүртэл яригдсаар ирлээ. Мах, махан бүтээгдэхүүн нь аль ч улсын стратегийн чанартай бүтээгдэхүүн. Тиймээс энэ чиглэлд улсын бодлого ч үйлчлэх ёстой. 2002 оны байдлаар Монголд нийтдээ АА зэрэглэлийн /ОХУ-ын мал эмнэлгийн албаны хяналтад орсон/ нэг ээлжиндээ 735 тн мах боловсруулах хүчин чадалтай 26 аж ахуйн нэгж махны экспортын чиглэлд үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол малын махны давтагдашгүй давуу шинжийг ашиглан эцсийн бүтээгдэхүүн боловсруулан гадаад, дотоодын зах зээл гаргахаар ажиллаж буй манай үйлдвэрлэгчдийг дэмжиж үйл ажиллагааг нь зөв гольдролд оруулах нь зүйтэй асуудал. Ингэснээр тэдний зүгээс төсөвт төлөх мөнгөний хэмжээ ч нэмэгдэнэ.

Яамд, мал эмнэлгийн газруудын хоорондын ажлын уялдааг сайжруулж, мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх ерөнхий зарчмыг нь урьдчилан тохирч, энэ тухайгаа аж ахуйн нэгжүүддээ цаг алдалгүй мэдээлдэг байх, харин аж ахуйн нэгжүүдийн хоорондын асуудалд төрийн зүгээс аль болох оролцохгүй байх чигийг барих ёстой.

Энэ өгүүллийн зорилго бол манай гол худалдан авагч болох ОХУ-ын мах, махан бүтээгдэхүүний зах зээл маань ерөнхийдөө ямархуу багтаамжтай, чухам ямар төрлийн мах, махан бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэдэг талаар болон Холбооны аль тойрогт хэрэглээ өндөр байгаа зэргийг ОХУ-ын ХААЯ-ны албан ёсны сайтыг ашиглан бичлээ. Өгүүлэлд орсон бүх тоо баримтууд тус яамны албан ёсных гэдгийг нэмж хэлье.

\*К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)


ОХУ нь 2003 онд 345 мян.тн /амьдын жингээр/ мал, шувууг илүү нядалсан. Голлон гахай шувууны үйлдвэрлэлээр илүү хангасан. Бодын тоо толгой хорогдсон. Махны бараг бүх төрлийн үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашиг нь муудсан. Өөрийн өртөг нь борлуулалтын өртгөөс давах болсон тул бодын болон гахайн махны борлуулалтаас гарах алдагдал нэмэгдсэн. Энэ алдагдлыг шувууны борлуулалт нөхөх болсон. ОХУ-ын Засгийн газраас 2003 онд махны импортыг хязгаарлах арга хэмжээ авсан нь түүний нийлүүлэлтийг багасгасан ба голлон шувууны махны хэмжээ нэлээд хорогдсон. Харин ТУХН-ийн орнуудаас нийлүүлэх импортын махны хэмжээ нэмэгдсэн. Учир нь эдгээр орнуудаас импортын хязгаарлалт байдаггүй. Харин хүн амын бодит орлогын өсөлт, мах боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн өсөлт зэрэг нь махан бүтээгдэхүүний боловсруулалтын өсөлтийг хангах нөхцөл болж байна.

2003 оны эхний хагаст махны үнэд өмнөх оны нөөцөлсөн махны хангамж нэлээд нөлөөлж байсан ба зөвхөн 3-р улирлаас махны үнийн өсөлт эхэлж он дуустал хадгалагдсан. Шувууны махны импортын квот нь үүнд хүчтэй нөлөөлсөн. 2004 оны эхээр махны үнэ ялангуяа гахай, шувууны махны үнэ нэлээд хэмжээгээр бордооны тарианы үнээс хамааралтай байсан. Статистик мэдээгээр бол ОХУ нь 2003 онд амьдын жингээр 7.7 сая.тн мах /мал, гахай, шувуу/ үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 4.7% нэмэгдсэн гэсэн үг.

### **ОХУ-ын мал, шувууны нядалгааны үйлдвэрлэл 2002-2003 онуудад /амьдын жингээр, мян.тн/**

	2002он	2003он	2002/2003 онд харьцуулсан байдал %
ОХУ	7316,2	7661,3	104,7
Холбооны тойрог "Центральный"	1543,5	1613,5	104,5
Холбооны тойрог "Северо-Западный"	420,6	439,4	104,5
Холбооны тойрог "Южный"	1312,5	1412,8	107,6
Холбооны тойрог "Приволжский"	2084,2	2160,9	103,7
Холбооны тойрог "Урал"	556,6	563,3	101,2
Холбооны тойрог "Сибирь"	1258,2	1329,0	105,6
Холбооны тойрог "Дальний Восток"	140,5	142,4	101,4


Дээрхи Холбооны тойргуудын махны үйлдвэрлэлд эзлэх хувийн жинг диграммаар харуулбал:




2002-2003 оны ОХУ-ын мал, шувууны нядалгааны үйлдвэрлэлийг аж ахуйн хэлбэрээр нь ангилбал /амьдын жингээр, мян.тн/

	2002 он	2003 он	2002/2003 онд харьцуулсан байдал %
Аж ахуйн бүх хэлбэрүүд	7316,2	7661,3	104,7
Үүнээс:			
ХАА-н үйлдвэр	3102,3	3344,2	107,8
Хувийн аж ахуй	4071,2	4144,9	101,8
Фермерийн аж ахуй	142,6	172,2	120,8

Хувийн аж ахуйн махны үйлдвэрлэлд эзлэх хувь өнөөг хүртэл өндөр хэвээр байгаа. 2000 оноос энэ хандлага хэдийгээр буух шинжтэй байгаа ч гэсэн. Фермерийн аж ахуйд өсөх хандлага байгаа ч эзлэх хувь нь маш өчүүхэн хэвээр байна. Үүнийг дараахи диаграммаас харж болно.



ОХУ-ын 2002-2003 оны мах бэлтгэлийг төрлөөр /амьдын жингээр, мянган тн/



Өнгөрсөн оны ургацын гарц мөн л махны үнэд нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл тэжээлийн үнэ өссөн гэсэн үг. Энэ нь гэхдээ гахайн аж ахуйд ихээр туссан. Малын тоо толгой хорогдоход аж ахуйнуудын эргэлтийн хөрөнгийн дутмаг байдал ихээр нөлөөлсөн. 2004 онд ХАА-д махны үйлдвэрлэлд сөрөг нөлөөлөх зүйл бол тэжээлийн хангамжийн асуудал зүй ёсоор орж байна.

### 2003 оны байдлаар ОХУ-ын малын нийт тоо толгойг аж ахуйн хэлбэрээр нь харуулбал. /сая толгойгоор/

	2003 оны IY сарын I	2003 оны YII сарын I	2003 оны X сарын I	2004 оны I сарын I
<b>Бод мал</b>				
Бүх төрлийн аж ахуйн нэгжүүдэд	27.7	27.9	26.6	25.0
<b>Үүнээс:</b>				
ХАА-н улсын үйлдвэрийн газруудад	15.3	14.9	14.0	13.5
Хувийн аж ахуйнуудад	11.6	12.1	11.8	10.8
Фермерийн аж ахуйнуудад	0.8	0.8	0.8	0.8
<b>Гахай</b>				
Бүх төрлийн аж ахуйн нэгжүүдэд	17.7	18.4	18.3	16.5
<b>Үүнээс:</b>				
ХАА-н улсын үйлдвэрийн газруудад	9.1	8.9	8.9	8.3
Хувийн аж ахуйнуудад	8.1	8.8	8.7	7.7
Фермерийн аж ахуйнуудад	0.5	0.6	0.6	0.6
<b>Хонь ямаа</b>				
Бүх төрлийн аж ахуйн нэгжүүдэд	17.3	19.0	17.8	16.2
<b>Үүнээс:</b>				
ХАА-н улсын үйлдвэрийн газруудад	5.1	5.9	5.2	4.5
Хувийн аж ахуйнуудад	10.2	11.0	10.5	9.9
Фермерийн аж ахуйнуудад	1.9	2.1	2.1	1.9

### 2002-2003 онуудад ОХУ-ын ХАА-н улсын үйлдвэрийн газрын мах үйлдвэрлэлийн зарим үзүүлэлтүүд

	2002он	2003он	2002/2003 онд харьцуулсан байдал %
<b>Бойжуулсан мал амьдын жингээр мян.тн</b>	3232.4	3215.9	99.5
<b>Үүнээс:</b>			
Бод мал	1411	1289	91,4
Гахай	736,8	739	100,4
Хонь, ямаа	51,5	50	98
Шувуу	1033	1135	110
<b>Хоногийн дундаж жин нэмэлт граммаар</b>			
Бод мал	380	373	98,2
Гахай	252	252	100
Хонь, ямаа	26	20	76,9
<b>100 эхээс авах төлийн тооцоо</b>			
Тугал	78	76	97,4
Тоорой	1421	1331	93,7
Ишиг, хурга	80	80	100
<b>Нийт сүргийн эргэлтээс бүх насны малын хорогдлын хэмжээ %</b>			
Бод мал	2.9	3.3	*
Гахай	9.5	10.7	*
Хонь, ямаа	5.9	5.3	*

2003 онд бүх төрлийн махны үйлдвэрлэлийн эдийн засгийн үр дүн өмнөх онтой харьцуулахад муудсан. Үүнийг дараахи хүснэгтээс харж болно. Үхрийн махны өөрийн өртөг нэмэгдснээр борлуулалтын үнийн алдагдал нэмэгдсэн ба хонь, ямааны махны орлого, зарлагын тэнцвэр ч алдагдах болсон. Гахайн махны борлуулалтын үнэ 11% буурсан ба өөрийн өртөг нь 2% нэмэгдсэн нь түүнийг алдагдалтай махны төрөл шилжүүллээ.


ОХУ-ын ХААЯ-ны санхүүгийн тайлангаар 1999-2003 онуудад мах борлуулалтын ашигтай байдлыг хувиар гаргасан нь:

	1999	2000	2001	2002	2003 урьдчилсан
<b>үйлдвэрийн боловсруулалт хийгдээгүй мах</b>					
Бод мал	-28,0	-30,0	-18,0	-23,0	-29,9
Гахай	-20,0	-24,0	2,0	-1,6	-10,7
Хонь, ямаа	-19,0	-4,0	3,0	8,7	2,2
Шувуу	-4,0	-9,0	-4,0	-6,5	-4,8

Импортын хориг арга хэмжээний дүнд импортын махны хэрэглээ багассан.

Үхэр, гахайн махны оруулалтад тарифын квот тогтоосон нь тэдгээрийн импортыг багасгахад хүргэсэн. 2003 оны 1-12 сарын байдлаар ОХУ-ын Гаалийн хорооны мэдээгээр бол /Беларусийг оруулахгүйгээр/ хөлдөөсөн болон шинэ махны импорт өмнөх өмнөөс 6.9%-иар багассан.


### **Хөлдөөсөн болон шинэ махны импортын бүтэц /2002-2003 онд %/**



Махны импорт багасаад ирэхлээр махан бүтээгдэхүүн, лаазалсан махны импорт 2002 онд 19.2 мянган тн байснаа 2003 онд 24.6 мянган.тн болж өссөн.

Махны импортод тарифын квот тогтоосон нь импортоор нийлүүлэгч орнуудын бүтцэд зарим өөрчлөлт оруулсан. Хөлдөөсөн


болон шинэ махны импорт ихэвчлэн гадаад орнуудаас авдаг тул нийт импортод түүний хувийн жин багассан. Энэ утгаараа ТУХН-ийн орнуудаас худалдан авах махны хэмжээ 28% өссөн. Дараахи диаграммаас харж болно.



ОХУ-ын гаалийн хорооны мэдээгээр бол 2003 оны I-IX сард үхрийн махны нийт импортын 39.6%-ийг ЕХ болон Бразилаас, 18.9%-ийг Украинаас тус тус импортолжээ. Гахайн махны 59.2%-ийг Бразилаас, 13.1%-ийг Польшоос, 12.7%-ийг ЕХ-ноос, 8.7%-ийг БНХАУ-аас тус тус импортолжээ.

Үхэр, гахайн махны контрактын үнэ 2002 оныхоос өссөн. Үхрийн махны 2003 оны 1 тонн махны дундаж үнэ 1140.8 ам.доллар байсан нь өмнөх оноос даруй 78 ам.доллараар өсчээ. Гахайн махны хувьд 1075.5 ам.доллар болж 140 ам.доллараар өсөв.

### Мах махан бүтээгдэхүүнийн хэрэглээнд /маханд шилжүүлснээр/ импортын эзлэх хувь




Мах боловсруулах үйлдвэрийн хөгжлийн хүчин зүйл бол махны нийлүүлэлт болон хүн амын төлбөрийн чалварын өсөлт байдаг. Хүн амын бодит орлого нэмэгдэхээр махны эрэлт мэдэгдэхүйц нэмэгдэхийг 2003 оны Оросын зарим үзүүлэлт харуулж байна. 2003 онд махны борлуулалт өмнөх оноосоо 6.1%-иар, хиаман бүтээгдэхүүн 7.6%-иар, лаазалсан мах 7.9%-иар тус тус нэмэгдсэн.


### 2002-2003 оны махан бүтээгдэхүүний үндсэн төрлийн үйлдвэрлэл /мян.тн/

	2002 он	2003 он	2002/2003 онд харьцуулсан байдал %
Мах болон I ангиллын дагавар бүтээгдэхүүн	1458,0	1608,0	110,5
Хиаман бүтээгдэхүүн	1467,7	1616,6	110,2
Хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн	408,5	456,4	111,7
Лаазалсан махан бүтээгдэхүүн	510,5	471,1	92,3

Импортоор оруулж ирэх махны шинэ дүрэм гарсантай холбоотойгоор өнгөрсөн жил төрөл бүрийн махны үнийн динамик янз бүрээр хувьсах болсон. ХАА-н байгууллагаас борлуулж байсан үхрийн махны үнэ сард дунджаар 1%-ийн өсөлттэй байсан. Ингэснээр үхрийн махны дундаж үнэ өнгөрсөн оны 12 сар гэхэд 1 тонн нь амьдын жингээр 22445 рублийн үнэтэй байлаа. Үхрийн махны үнийн өмнөх оны тухайн сартай харьцуулсан харьцаа %-иар:



ХАА-н үйлдвэрлэгчдийн малын /үхэр, гахай/ үнэ 2003 оны байдлаар 1 тонн мах нядалгааны жингээр /мянган рубль/.



Боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэгчдийн үнэ үхэр, гахайн маханд 2003 оны 1-р хагаст хэлбэлзэлтэй байсан ч 2-р хагасаас тогтвортой өсөж эхэлсэн ба гахайн мах илүү хурдацтай өссөн. 2003 оны 12 сард үйлдвэрлэгчдийн үнэ 2002 оныхоос 1.3%-иар нэмэгдсэн. Харин хэрэглээний зах зээл дээр үхэр, гахайн махны үнэ тийм ихээр нэмэгдээгүй.

Мах, махан бүтээгдэхүүний үнийн индексг 2002 оны 12 сарыг 2003 оны 12 сартай харьцуулсан хувиар харуулбал:

	Боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэгчдийн үнэ		Хэрэглээний үнэ	
	2002	2003	2002	2003
Үхрийн мах	97,2	101,3	103,1	102,1
Гахайн мах	93,1	106,1	102,5	102,6
Шувууны мах	102,1	125,8	-	-
Тахиан мах	-	-	103,1	119,5
Тахиан гуя	-	-	98,6	126,6
Зайдас	104,3	106,5	106,5	107,8
чанамал хيام	105,3	106,6	106,0	107,1

Дээрхээс харахад ОХУ нь махны бодлогодоо дотоодын үйлдвэрлэгчид, аж ахуйн нэгж, хувийн аж ахуйг тууштай хамгаалахыг зорьж байна. Махны жижиглэнгийн үнэ дунджаар 1.8-3.2 ам.доллар байна.

Улсын хэмжээгээр махны нөөц сайтай байдаг нь үний огцом өсөлтийг хязгаарлаж байдаг юм байна. ТУХН-ийн орнуудаас импортлодог маханд импортын квот тогтоодоггүй юм байна. Гахай, тахианы махны хэрэглээ өндөр байдаг юм байна.

Монголын мах экспортлогчид дээрхи тоо баримтуудыг харгалзахаас гадна бусад хүчин зүйлийг харгалзан үзэж ОХУ-ын махны зах зээлд хөл тавьж байх нь тэдний бизнест сайн талтай байх болов уу гэдгийг давхар сануулъя.